

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23-Р СУРГУУЛИЙН

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ:А.СОЛОНГЫН 2018-2019 ОНЫ

ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ТӨЛӨВШИЛ: Оролцоо

- Ангийн нийт сурагчдыг сургуулийн орчинд дасан зохицох ,сурах арга барил эзэмшүүлэх үүднээс сургалтыг тогтмол хүүхдийн сонирхолд нийцүүлэн сургалтыг зохион байгуулж байна. Ингэснээр хүүхдүүдийн хичээлд оролцох идэвхи нь сайжирж байна
- Сургуулийн орчинд ба сургалтын явцад биеэ зөв авч явах үүднээс ангийн болон сургуулийн дэгийг боловсруулан дэгийг тогтмол таниулан ажиллаж байна. Үүний үр дүнд сурагчид маань сургуулийн орчинд чанга дуугаар ярихгүй, гүйж харайх нь багассаар байна
- Олон нийт ба анги танхим сургуулийн орчинд зөв боловсон харьцах тал дээр зөвөлгөө өгөн ажиллаж байна
- Ангийн сурагчид оролт , таралтын дэгийг тогтмол гүйцэтгэснээр оролт ,таралтын дэгийг хэрэгжүүлж хэвшсэн
- Даваа гараг бүрийн эхний цаг дээр Төрийн дуулал 100% сурч дуулж байна
- 3-р цагийн завсарлагаанаар Хөдөлгөөнт гимнастик хийж байна

Дадал хэвшил

- Бид дүрэмт хувцсаа тогтмол цэвэр сайхан өмсөж хэвшсэн.
- 2 ба 3-р ээлжийн хооронд жагсаж хэвшин,хичээл тарахдаа жагсаалаар гарах чадварыг хангалттай сайн хэвшүүлж байна.
- Гадуур хувцсаа өөрөө өмсөж,тайлан шүүгээндээ хийж сурлаа.
- Хичээлийн хэрэглэгдэхүүнийг ариг гамтай , зөв хэрэглэх тал дээр зөвлөн тусалж анхаарал хандуулан ажилсаны үр дүнд сурагчид маань хичээлийн хэрэглэлдээ ариг гамтай хандах чадварт суралцсаар байна
- Үдийн цайгаа уухаас өмнө гарын ариутгалыг тогтмол хийж хэвшсэн.
- Хогоо хогийн саванд хийж хэвшиж байна
- Гэрийн даалгавраа тогтмол хийж хэвшлээ
- Хөдөлгөөнт дасгалыг хийж хэвшив.

Зан чанар

- Сургуулийн дэгийг баримтлах тал дээр бие биендээ шаардлага тавихдаа аядуу зөөлөн дуугаар,зөв хандлагатай шаардлага тавих арга барилд суралцаж байна.

- Баярласан ,талархсан сэтгэлээ зөв боловсон илэрхийлэн сурах үүднээс үдийн цайгаар үйлчилдэг гал тогооны эгч нартаа талархлын үгсийг хэлж сурч байна
- Сургуулийн багш ,ажилтан ,өөрөөсөө ахмад хүнтэй мэндлэх хүндлэх зан чанарыг хүүхдүүд маань хангалттай сайн эзэмшиж байна.
- Өөрийгөө болон гэр бүлээ танилцуулж сурсан
- Зөв эрүүл харилцаа гэж юу болохыг мэдэж зөв харилцааг эрхэмлэж сурч байна.
- Бусдыг хүндлэх баярласан сэтгэлээ илэрхийлэх ба уучлалт гуйж сурч байна.
- **СУРАГЧ НЭГ БҮРИЙН СУРЛАГЫН АМЖИЛТ :**

Гарсан ахиц:

- Хичээлийн жилийн эхэнд гарааны оношилгоо авч сурагчдыг оношилсон.Үүнд:Үзэг, харандаа барьж зурж бичих чадвар сул 2 сурагч байсан бол одоогийн байдлаар ангийн бүх сурагчид үзэг , харандаагаа барин бичиж , зурж сурсан.
- Монгол хэлний хичээлээр ангийн нийт сурагчдын 80% нь эгшиг 7 ба 1-р шатны гийгүүлэгч үсгийг таньж, цэвэр сайхан бичиж , уншиж сурсан.
- Харин сурагчдын 70% нь нэг үетэй үгийг, 60% нь хоёр үетэй үгийг цээжээр бичих чадварт суралцсан.
- Математик хичээл дээр ангийн нийт сурагчдын 85% нь 10 хүртлэх цифр ба тооны бүтцийг таньж, нэмэх,хасах үйлдлийг гүйцэтгэн ,цэвэр сайхан бичиж сурсан.
- Ангийн 13 сурагч Математик сонины нэрэмжит намрын сорилго олимпиадад оролцлоо.Үүнээс:Сурагч: Үжин, Сувд, Солонго, У.Эрхэмбаяр, Индра нар амжилттай оролцон дунджаас дээгүүр үнэлгээтэй шалгагдсан.
- Ангийн нийт сурагчдын 87% нь уншиж, бичиж,бодож сурсан байна.
- Эхний хагас жилд сурагчдын 75% нь уншиж чаддаг байсан бол хичээлийн жилийн төгсгөлд ангийн сурагчдын 87% нь уншиж бичиж сурсан байна.
- Ангийн сурагчид энэ хичээлийн жилд нийт 18 шүлэг цээжлэн тогтоон түүнийгээ уран тод унших аргад суралцаж байна
- Нийт сурагчдын 90% нь цаас нугалан бяцхан ном хийх аргад суралцан, өөрийн чадвараар бяцхан ном хийн бүтээлийн үзэсгэлэн гаргалаа.

АВЬЯАС ЧАДВАРЫГ НЭЭСЭН БАЙДАЛ:

- Энэ хичээлийн жилийн эхний хагасд ангийн нийт сурагчдыг зөв алдаагүй,цэвэр сайхан бичих чадварт суралцаж байна.
- Ангийн сурагчдын эцэг эхээс авьяасын судалгаа аван нэгтгэн дүгнэлээ.
- Ангийн сурагчдын 15% нь буюу 8 сурагч дугуйлан секцэнд хамрагдсан байна.
- Сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх зорилгоор анги бүр Математик сонины хайчилбар хийж сургалтандаа ашиглалаа.

- Цэвэр сайхан бичих аяны хүрээнд 3 удаагийн давтамжтай ангидаа цэвэр бичгийн уралдаан зарлаж эцэг эхчүүдэд танилцуулав
- Улиралд 2-оос доошгүй сурагчдын бүтээлээр бүтээлийн үзэсгэлэн гаргалаа

АВЬЯАСЫГ ХӨГЖҮҮЛСЭН БАЙДАЛ:

- Ангийн нийт сурагчид 18 шинэ шүлэг цээжлэн уран тод унших аргад суралцаж байна
- Сурагчид баримлын шавраар Чагтан хээг урлан ,урласан бүтээлээр нь бүтээлийн үзэсгэлэн гарган эцэг эхэд нь танилцуулав.
- Ангийн сурагчдын дунд Цэвэр сайхан бичигтэн болцгооё “ нэрийн доор цэвэр бичгийн уралдааныг 3 удаа зохион байгуулав.
- Ангийн сурагчдын боломжит бүх л бүтээлээр нь ангидаа бүтээлийн үзэсгэлэн гарган урамшуулан сайшаан ажиллаж байна.Ингэснээр хүүхдийн бүтээл бүтээх чадвар нь ахисаар байна
- ХГА үйл ажиллагааны цагаар сурагчдын ярих чадварыг хөгжүүлэх зорилгоор өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ танилцуулах ярилцлагыг зохион байгуулав.
- “Бид нэгдүгээр ангийнхан” өдөрлөгт зориулан олон төрлийн бүтээлээр сургуулийн орчин болон анги танхимд бүтээлийн үзэсгэлэн гарган багш .эцэг эх, найз нөхдөдөө танилцуулав.
- Сурагчдын бүтээх чадварыг хөгжүүлэх зорилгоор бяцхан ном хийх аргад суралцан сурагчид Миний мэдэх оньсого, Ертөнцийн гурав,Миний дуртай үлгэр сэдвээр тус тус бяцхан ном бүтээлээ.

Сургууль олон нийтийн ажилд оролцсон байдал

№	Хугацаа	Үйл ажиллагааны нэр	Зохион байгуулсан газар	Үүрэг оролцсон байдал
1	9 сар	Нэг баг нэг арга зүй ур чадварын уралдаан	23-р сургууль	Багаараа 1-р байр
2	9 сар	Багш нарын буухиа тэмцээн	23-р сургууль	Багаараа 1-р байр
3	10 ,4 сар	Мод тарих	23-р сургууль	Сургуулийн ногоон байгууламжийг цэвэрлэсэн
4	10 сар	Дадлага удирдах сургалт	Багшийн сургууль	Дадлага удирдах талаарх мэдлэгээ сайжрууллаа

5	Жилийн турш	Мүүдль сургалт	23-р сургууль	Мүүдль системийг ашиглах сургалтанд тасралтгүй хамрагдлаа
6	Жилийн турш	Цэнэглэх цаг	23-р сургууль	Энэ хичээлийн жилийн турш бүх л Цэнэглэх цагт хамрагдан хуулийн хэрэгжүүлэлт болон эрүүл мэндийн талаарх мэдлэгээ ахиулав
7	Жилийн турш	Сургуулийн болон ЗАН хурал	23-р сургууль	Цаг үеийн байдлын талаарх мэдээллийг тогтмол авдаг
8	1 сар	Чингэлтэй дүүргийн Математик судлагдахууны сургалт	39-р сургууль	Бага ангийн багш нарын заавал бодох 500 бодлого номноос бодлого бодох аргад суралцав.
9	1 сар	АУБ нарын анхдугаар зөвлөгөөн	23-р сургууль	Анги удирдах урлаг сэдвийн хүрээн секц хамт олноороо илтгэл бичин оролцлоо
10	2 сар	Төсөл хэрхэн бичих	23-р сургууль	Төсөл хэрхэн бичих талаарх тодорхой ойлголт авлаа.
11	3 сар	Шилдэг хэрэглэгдэхүүн шалгаруулах уралдаан	23-р сургууль	Секцээрээ хамтран амжилттай оролцон ЧД-ийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэв
12	3 сар	ҮЭ-ийн хурал Удирдлагаа солих	23-р сургууль	ҮЭ-ийн гишүүдээ шинээр сонгох ажилд өөрийн санаа өгч оролцлоо

13	3 сар	ЕШ-ийн ерөнхий шалгалтанд хянагч багш	52-р сургууль	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан ЕШ-ийн ерөнхий шалгалтанд хянагч багшаар ажиллалаа.
14	3 сар	ЭЭНХ-ны өдөрлөгт хамрагдлаа	23-р сургууль	Ангийн эцэг эхийн 85%-ийг ЭЭНХ-ны өдөрлөгт хамруулж сургуулийн бодлого санаачлагыг танилцуулав
15	4 сар	Бүх нийтийн цэвэрлэгээ	23-р сургууль	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан энэхүү ажилд сургуулийнхаа ногоон байгууламж болон хашааг угааж цэвэрлэв.
16	5 сар	Бид нэгдүгээр ангийхан өдөрлөг	23-р сургууль	Бид нэгдүгээр ангийхан өдөрлөгийг амжилттай сайн зохион байгуулан өнгөрөөлөө.

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ:

Эцэг эхийн сэтгэл ханамж:

- Эцэг эхийг сургалтын үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор улиралд 1-2 удаа эцэг эхийн хурлыг зохион байгуулан санаа бодлоо хуваалцан хэрхэн бодуулах, уншуулах, бичүүлэх тал дээр зөвөлгөө өгөн эцэг эхээс гаргасан оновчтой санаа бодлыг сургалтандаа хэрэгжүүлж байна.
- Үдийн цайны амталгаат өдөрлөгт эцэг эхийг хамрууллаа.
- Эцэг эхээ дөрвөн багт хуваан улирал бүр эцэг эхийн оролцоотой ажлуудыг төлөвлөн төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа.

Үүнд: I-р баг Эцэг эхийн нэг өдөр, Амны хөндийн ариун цэврийн талаар сургалт

II-р баг Үдийн цайны эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилгоор ангийн нийт 56 сурагчийн аяганы уутыг эрүүл мэндийн шаардлагад нийцсэн уутаар жигдрүүлэв.

III р баг “Аав , ээж, би “ тэмцээнийг ангийн хүрээнд амжилттай зохион байгуулж

IIр багийн эцэг эхчүүд шилжин явах цомын эзэн боллоо.

IV р баг Ногоон байгууламж бидний ирээдүй нэрийн доор цэцэрлэгт хүрээлэнд ангийн нийт сурагч эцэг эхчүүд хамрагдан 23 ширхэг модыг тарьлаа.

- ЭЭНХ –ны өдөрлөгт хамрагдан сургуулийн MOODLE системийн талаарх анхны ойлготыг авч нэвтрэн орон анхны мэдлэгтэй боллоо
- Эцэг эхчүүдийн анхны зөвлөгөөнд сурагч Содбилэгийн ээж оролцон “Сургууль багш эцэг эхийн харилцаа” сэдвээр илтгэл тавьлаа.
- Бид нэгдүгээр ангийхан өдөрлөгт ангийн нийт эцэг эхчүүд 100% хамрагдан хүүхдийнхээ болон ангийн нийт сурагчдын бүтээл ба сурсан дуу шүлгээс үзэж сонирхлоо.

Сурагчийн сэтгэл ханамж:

- Нэгдүгээр ангид элсэн орсон болон сургуулийн орчинтой танилцах зорилгтой сургуулийн орчинтой танилцуулав.
- Ном унших сайхан сэдвийн хүрээн сургуулийн номын сангаараа аялаж ном хэрхэн зөв унших талаарх зөвлөгөөг номын санчаараа дамжуулан хүргүүллээ.
- Ангийн сурагчдын бүтээлээр ангидаа бүтээлийн үзэсгэлэн гарган урамшуулан магтан сайшаан ажиллаж байна.
- Ангидаа цэвэр сайхан бичигтэнг шалгаруулав.
- Ангийн сурагчид Төрийн дууллаа 100% дуулж сурсан
- Өдөр бүр хөдөлгөөнт гимнастик хийж байна

ЭРҮҮЛ МЭНД:

- Гар угаах өдрийг тохиолдуулан “Гараа хэрхэн зөв угаах “ талаар сургалт зохион байгуулла
- Амны хөндийн ариун цэврийн талаарх сургалтыг зохион байгууллаа \1-р багийн эцэг эхийн тусламжтайгаар \
- Сургуулийн эмчтэй хамтран ангийн сурагчдыг 100% өндөр жингийн үзлэгт хамрууллаа
- 3-р цагийн завсарлагаанаар нүдний дасгал хийж хэвшсэн .
- Хөдөлгөөн бол эрүүл мэнд хэмээн заавал өдөр бүр дасгалыг хийж байна
- “Эрүүл шүд эрүүл хүүхэд “ аяны хүрээнд хүүхэд бүрийг зуны амралтаараа шүдээ эрүүлжүүлэх мөн хяналтын дэвтрийг хэрхэн хөтлөх санамжийг эцэг эхэд өглөө
- Ангийн 3 сурагчийг долоо настайд хамрагдах вакцинд хамруулав. Үүнд:сурагч Содбилэг, Б.Мишээл. У.Эмүжин нар хамрагдлаа
- Сурагчдыг өдөр бүр витаминжуулалтын аянд эцэг эхийн тусламжтайгаараар хамрууллаа.
- Эрүүл орчинд сурч хүмүүжих талаар тогтмол яриа таниулга хийн ангийн жижүүр хийх ажлыг эхлүүлэн амжилттай явагдаж байна

ЭРҮҮЛ ХАРИЛЦАА:

- Өөрөөсөө ахмад ба багш ажилчидтай мэндлэх чадварыг эзэмшиж байна
- Баярлалаа үгийг зөв үед, зөв хэлж хэвших тал дээр ангийн багшийн зүгээс анхаарал хандуулан ажиллаж байна.
- Үдийн цайгаар үйлчилдэг гал тогооны эгч нартаа талархлын үгийг хэлж хэвшсэн.
- Зөв харилцаатай сурагчдыг урамшуулах үлгэр жишээ болгох ажлыг тогтмол явуулж байна.
- Сургуулийн ажилтан ба ангийн үйлчлэгч Мөнхтуяа эгчтэй туслах үүднээс орой бүр ангийн жижүүрийг хуваарлин ажиллуулж байна

ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН:

- Сурагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор хичээлийн улирлын амралт ба зуны амралт эхэлсэнтэй холбогдуулан хүүхдийг эцэг эхийн хяналтанд хүлээлгэн өгөн эцэг,эхээр гарын үсэг зуруулан баталгаажууллаа
- Ангийн сурагчдыг Гараас гарт хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж байна.
- Ангийн сурагчдыг 100% цүнхний цацруулагчтай болгосон
- Сургуулийн зүгээс өгч байгаа анхааруулга сануулгыг тогтмол сурагчид болон эцэг эхэд танилцуулж гарын үсгээр баталгаажуулж байна
- Хичээл тарахад өдөр бүр 5 минут Замын хөдөлгөөний дүрэм тэмдэг тэмдэглэгээ ба аюулгүй байдлын талаар мэдээлэл хийж хэвшлээ
- Ангийн сурагчдаас эрсдлийн судалгаа аван нэгтгэн дүгнэлээ
- Сургуулийн болон сурагчийн дүрмийг дадал хэвшил болгоход өдөр бүр анхааран ажиллаж байна.

Дүгнэлт.

Хүүхэд нэг бүрийг сургууль , багш , найз нөхөд нартайгаа дасан зохицох ,сурах арга барил эзэмшүүлэх, нийгэмшихэд туслах үүднээс хүүхдийн сонирхол, онцлогт нийцүүлэн сургалтын явц болон хичээлээс гадуурх үйл ажлыг зохион явуулснаар сурагчдын оролцоо , хандлага, сургуульд дасан зохицох тал дээр ахиж амжилт нь сайн байна. Цаашид сургалт үйл ажиллагаагаа чанартай явуулан хугацаанд нь эзэмшвэл зохих мэдлэг,чадварыг эзэмшүүлэхэд туршлагатай багш нар болон сургалтын албанаасаа зөвлөгөө зөвлөмж аван ажиллах болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ:

А.СОЛОНГО



Бид эцэг эхчүүдийхээ тусламжтайгаар өдөр бүр витаминжуулах аянд хамрагдан цэвэр аюулгүй аяганы ууттай болсон



БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ:

Эцэг эхийн сэтгэл ханамж:



Эцэг эхийн нэг өдөр



Аав, ээж би тэмцээн маань амжилттай сайхан зохион байгуулагдлаа.



Бид ангиараа мод тарьлаа.



АВЬЯАСЫГ ХӨГЖҮҮЛСЭН БАЙДАЛ:



Бүтээл урлах явцаас

Бидний бүтээл





Бидний оролцоо ба дадал хэвшил



Дээлтэй Монгол өдөр





Хөдөлгөөн бидний эрүүл мэнд

Даваа гараг бүрийн эхний цаг дээр Төрийн дууллаа дуулж хэвшсэн



Дүрэмт хувцсаа зөв өмсөж хэвшлээ бид.



Сурагчдын Математик сэтгэлгээг нэмэгдүүлэх зорилгоор сонины хайчилбар хийж сургалтандаа ашиглаж байна.



Унших, ойлгох чадварыг ахиулах зорилготой сургуулийнхаа номын сангаар аяллаа.

Бид уншиж, бичиж, бодож сурснаа сургууль, багш, эцэг эхчүүддээ тайлагналаа



